

ДОКТОР Л.ЖАМСРАНГИЙН 70 НАСНЫ ОЙД

**МОНГОЛЫН НЭРТЭЙ ТҮҮХЧ -
ДОКТОР, ПРОФЕССОР Л.ЖАМСРАН**

Н.АРИУНГУА*

Жамсран гуай ШУА-д 30 гаруй жилийн турш ажиллаж олон арвин шинжилгээний бүтээл зохиолыг туурвиж түүхийн шинжлэх ухааны салбарт багагүй хувь нэмэр оруулсан юм.

Жамсран гуай Хэрээд овгийн хүн бөгөөд 1929 онд одоогийн Сүхбаатар аймгийн Халзан сумын нутагт төрж нутагтаа бага, дунд сургууль, 1953 онд МУИС-ийн түүхийн анги, 1962 онд Бээжингийн Их сургуулийн аспирантурыг тус тус дүүргэж Монгол Улсын их, дээд сургууль, ШУА-д олон жил үр бүтээлтэй ажилласан эрдэмтэн, сурган хүмүүжүүлэгч, ардын боловсролын тэргүүний ажилтан юм. ШУА-ийн түүхийн хүрээлэнгээс эх түүхийн судлалд дорвитой хувь нэмэр оруулсан бүтээлд олгодог Х.Пэрлээгийн нэрэмжит шагналыг 1995 онд “Монголын сэргэн мандалтын эхэн” гэдэг зохиолоороо хүртсэн юм. Төр засгаас Л.Жамсран гуай шинжлэх ухааны салбарт оруулсан гавьяа зүтгэлийг нь өндрөөр үнэлж 1996 онд Алтангалас одонгоор шагнасан байна. Л.Жамсран гуай “Манай эх орны түүхэн замнал” /1968/, “Соёл эрдэнэ” /1970/, БНМАУ-ын түүхийн сурах бичиг /1972, 1975, 1978/, “Жанжин манлай баатар Дамдинсүрэн, түүний шинэтлэлийн бодролууд” /1991/, “Монголын сэргэн мандалтын эхэн” /1992/, “Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт” /1997/, “Дарьганга” /1999/ зэрэг түүхийн судлалаар 14 бүтээлийг туурвиснаас гадна 10-аад хамтын бүтээлд оролцсон юм.

Жамсран гуай Монголын үндэсний эрх чөлөөний тэмцлийн түүхийг нарийвчлан судалсан ба энэ сэдвээр түүний хийсэн зүйл нь үлэмж их юм. Тухайн сэдвээр дээр дурдсан нэгэн сэдэвт зохиолуудаас гадна олон арван эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлсэн юм. Тэдгээрээс цухас дурдваас: “XVII зууны эхний өмнөд Монгол ба Манжийн түрэмгийлэл”, “Манж Чин улс Монголд шинэ засгийн бодлогоо хэрэгжүүлэхийг оролдсон нь”, “1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдагч”, “Хятадын 1924-1927 оны хувьсгалыг МАХН дэмжиж байсан нь” зэрэг бөгөөд эдгээр нь 2000 онд манай хүрээлэнгээс эрхлэн нийтлүүлсэн Жамсран гуайн 80, 90-ээд онд туурвисан өгүүлэл илтгэлийн түүврийн 1-р дэвтэрт орсон болно.

“Монголын тусгаар тогтнолын сэргэлт” /1997/ хэмээх нэгэн сэдэвт зохиолд олон жилийн турш түүний хийсэн судалгааны үр дүн туссан байх бөгөөд чухамхүү энэхүү зохиолд тэрээр XX зууны эхний

*Н.Ариунгуа - Олон улс судлалын хүрээлэнгийн Хятад судлалын салбарын эрхлэгч, дэд доктор

Монголын түүхийн зангилаа асуудлаар өөрийн санаа дүгнэлтүүдийг бататган лавшруулсан ба үзэл баримтлалын хувьд шинэ зүйлийг дэвшүүжээ. Тухайлбал, Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлтийн талаар урьд өмнө гарсан гадаад, дотоодын эрдэмтдийн бүтээлүүдэд манай улсын тусгаар тогтнолын асуудлыг бараг дан ганц гадаад хүчин зүйлээс хамааралтай байсан гэсэн хэт нэг талыг баримталсан үзэл баримтлалд шүүмжлэлтэй хандаж, төрийн тусгаар тогтнолын сэргэлт нь юуны түрүүнд чухамхүү монголчуудын өөрсдийн санаачлага шаргуу тэмцлийн үр дүн байсныг нээн харуулжээ. Чингэхдээ гадаад хүчин зүйлийн үр нөлөөг түүхийн арвин их материал дээр тулгуурлан тодорхойлсон байна. Мөн 1911-1915 оны хооронд Монголд өрнөсөн тусгаар тогтнолын төлөө тэмцлийн түүхийг үечлэн шинж чанарыг нь нарийвчлан тодорхойлсон юм. Улмаар түүхийн судлалд 1911-1912 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гэдэг байсныг 1911-1915 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал гэж нотлоод, түүнийгээ дотор нь Чин улсыг эсэргүүцсэн, Дундад Иргэн Улсыг эсэргүүцсэн гэсэн үндсэн хоёр шаттай байсан хэмээн нотолжээ. Түүнчлэн Богд хаант Монгол улсыг “Олноо өргөгдсөн Монгол улс” хэмээх албан ёсны нэрээр нь нэрлэх саналыг дэвшүүлж үүнийг нь нийтээр хүлээн зөвшөөрчээ.

Жамсран гуай Монголын дундад зууны үеэр багагүй судалгааны ажил, бүтээл туурвилыг хийсэн бөгөөд хамгийн сүүлд л гэхэд “Хаадын намтар” цувралд “Эсэн хааны намтар” нэгэн сэдэвт зохиол, Монгол улсын түүхийн 5 ботийн 3-р ботийн редактор, мөн 5-р ботид зохиогчоор оролцож байна. Доктор Жамсран нь тухайн үеийн Монголын түүхийн судалгааг сурвалж материалаар баяжуулах ажилд багагүй хувь нэмэр оруулсан бөгөөд тухайлбал, XIV-XVI зууны үеийн Монголын түүхтэй холбоотой “Ванли хааны байлдааны гавьяаны тэмдэглэл” хэмээх хятад сурвалж бичгийг эртний хятад хэлнээс монголчилсон бөгөөд түүний энэ орчуулга Монгол улсын номын санд хадгалагдаж байдаг ба дундад зууны үеийн Монголын түүхийг судлаач бид нарын судалгааны ажилд сурвалж материалын хувьд маш их тус дөхөм болдгийг тэмдэглэж хэлмээр байна. Түүхийн шинжлэх ухааны чухал нэг үүрэг бол түүхийн мэдлэгийг ард олонд түгээх явдал бөгөөд түүхч бидний өмнө улс үндэстнийхээ түүхийг судлан улс үндэстнээ гэсэн үндэсний бахархал эх оронч үзлийг төлөвшүүлэн энэхүү үзлийн үндсэн дээр үндэсний нэгдлийг хангах чухал зорилт ямагт тавигдаж байдаг билээ. Тэгвэл Жамсран гуай түүхч хүний энэхүү эрхэм үүргийг нэр төртэй биелүүлсээр ирсэн бөгөөд хэдий түүний бүтээл туурвилын ажил, амьдралд багагүй бэрхшээл, зовлон учирч байсан боловч тэрэр түүхийн шинжлэх ухаанд үнэнч байж, эрдэмтэн хүний өндөр ёс суртахууныг хадгалсаар ирсэн юм.

Жамсран гуай манай улсын ерөнхий боловсролын дунд сургуулийн 9-10-р ангид үзэх Монголын түүхийн анхны сурах бичиг бичсэн, тэрхүү зохиол нь 1972-1978 оны хооронд 3 удаа хэвлэгдсэн байна. Г.Сүхбаатар агсны хамт “БНМАУ-ын түүхийн дээж бичиг” нэрээр

1968 онд анхны түүхийн унших бичгийг эмхтгэн гаргасан юм. Гэвч эдгээр зохиолуудыг бичсэний улмаас улс төрийн хэлмэгдэлд зүй бусаар өртсөн бөгөөд хожмоо цагаатгагдсаныхаа дараа Г.Сүхбаатарын хамт дээж бичгээ нэмж засварлан тус бүр хоёр дэвтэр болгон 1992 онд хэвлүүлсэн байна. Монгол түүх суралцагч, суралцагч нарт зориулан хамтын бүтээл болох "Монголын түүхийн бага нэвтэрхий толь" хэмээх 5 боть гаргахаар чармайн ажиллаж эхний хоёр ботийг хэвлүүлээд 3-р ботио энэ онд гаргах зорилготой ажиллаж байна.

Доктор Жамсрангийн эрдэм шинжилгээний үйл ажиллагааны талаар ярихдаа Монголын хятад судлалд оруулсан түүний хувь нэмрийг дурдахгүй байхын аргагүй юм. ШУА-ийн Дорно дахины хүрээлэн, Олон Улс Судлалын хүрээлэнд ажиллаж байх хугацаандаа тус хүрээлэнгийн Хятадын дотоод улс төр судлалын сэдвийг удирдаж түүний удирдлагын дор "Өнөөгийн Хятад орон", "Хятад дахь монголчууд", "Өвөр Монголын өөртөө засах орон" хамтын бүтээлүүд хэвлэгдэн гарсан юм. Мөн "Хятад, англи, орос, монгол бичгээр хятад үг галиглах харьцуулсан лавлах" бие даан хийж монгол хэлэнд хятад үгийг галиглах асуудлыг нэг мөр болгоход хувь нэмрээ оруулсан юм.

Жамсран гуай манай улсад гарч буй түүхийн талаарх шинжилгээний зохиолуудыг редакторлахад багагүй цаг зарцуулж 11 бүтээлийн редактораар ажилласан байна. Жамсран гуайг олон улсын хэмжээнд түүхчид сайн мэддэг ба түүний зохиол бүтээлээс нь гадны олон эрдэмтэд судалгаандаа өргөнөөр ашигладаг юм.

Профессор Жамсран нь сурган хүмүүжлийн ажилд багагүй хүч чадлаа зориулж, түүхийн хичээлийг дунд сургуульд заах арга зүйн зааварчилгаа бичиж нийтлүүлсэн ба манай улсын дээд сургуулиудад Монголын түүхийн бүхий л үеэр лекц уншиж, эрдэм мэдлэгээ түгээж яваа хүн юм. Түүхийн судлалд шинэ халааг бий болгох энэ үйлсэд чамлаалгүй ажиллаж түүхийн ухааны салбарт сүүлийн хэдэн жил гэхэд л 5 хүний магистр, дэд докторын зэрэг горилсон зохиолын эрдэм шинжилгээний удирдагчаар ажилласан ба 10 хүний эрдмийн зэрэг хамгаалахад албан ёсны шүүмжлэгч хийсэн байна.

Эрдэм шинжилгээний ажил, түүн дотроо түүхийн шинжлэлийн ажил нь эрдэм мэдлэг, өндөр боловсрол, эрдэм шинжилгээний мэдрэмж, логик сэтгэлгээ, үзэл бодлоо илтгэн гаргах ур чадвар, нэг үгээр хэлбэл авьяас, түүн дээр тэвчээр, махруун ажиллах чадвар, эрдэмт хүний ёс суртахуун зэргийг шаарддаг ба тэр бүр хэн дуртай нь хийж чадах амар ажил биш билээ. Жамсран гуай дээрх бүх чанарыг өөртөө агуулсан хүн бөгөөд түүхийн шинжлэх ухаанд зориулсан амьдралын 30 гаруй жилийн хугацаанд эрдэмтэн хүний нэр төрийг өндөрт өргөж, бүтээл туурвилаараа нэрд гарсан манай нэрт түүхчдийн нэг юм.

Ингээд Жамсран гуайн цаашдын эрдэм номын ажилд улам их амжилт, амьдралд нь аз жаргал, эрүүл мэндийг хүсэн ерөөе.